

Монгол Улс - Хүүхэд хөгжил судалгаа 2000

Үндэсний Статистикийн Хороо - ҮСХ

Үүссэн огноо: June 23, 2014

Вэб хуудас: <http://web.nso.mn/nadamn/index.php>

Тойм

Тодорхойлолт

ДУГААР

MNG-NSO-MN-MICS2000-v3.0

Хувилбар

ХУВИЛБАРЫН ТАЙЛБАР

Хувилбар 2.0:Засварлагдсан мэдээллийн бааз

ҮҮССЭН ОГНОО

2000-09-15

Тойм

ТОВЧ

НҮБ-ын Хүүхдийн Сангийн техник, санхүүгийн дэмжлэгтэйгээр Монгол Улсад явуулсан "Хүүхэд, хөгжил-2000" судалгаа нь Монгол улсын хүүхэд, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, амьдралын нөхцөл байдлыг сайжруулахын тулд төр, засгаас өнгөрсөн 10-аад жилд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйл ажиллагааг үнэлж цэгнэхэд маш чухал ач холбогдолтой болсон. Судалгааны үндсэн зорилго нь Монгол Улсаас Хүүхдийг 2000 он хүртэл хөгжүүлэх талаар баримтлах үйл ажиллагааны Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлыг хянан дүгнэх, цаашид авах арга хэмжээг боловсруулахад шаардлагатай тоон мэдээллийг бүрдүүлэх явдал юм. "Хүүхэд, хөгжил -2000" судалгааны үр дүн нь Монгол улсын нялхас, хүүхэд, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсролын өнөөгийн түвшин, тухайн үйлчилгээнүүдийн хүртээмж болон тэдгээрт нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг тодруулахад чухал ач холбогдолтой мэдээллийн эх үүсвэр болсон.

"Хүүхэд, хөгжил-2000" судалгааны үндсэн зорилго нь:

-Хүүхдийг хөгжүүлэх талаар 2000 он хүртэл баримтлах үйл ажиллагааны Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хянан, дүгнэх;

-Хүүхдийн төлөө Дэлхийн дээд хэмжээний уулзалтаас дэвшүүлсэн зорилтуудын ололтыг дүгнэж, 21-р зууны эхний арван жилд хийх үйл ажиллагааны үндэс болох тоон мэдээллийг цуглуулах;

-Монгол Улсын энэ чиглэлийн мэдээллийн болон хяналтын тогтолцоог боловсронгуй болгон сайжруулахад хувь нэмэр оруулж, энэхүү тогтолцооны загвар, түүний хэрэгжилт болон мэргэжилтнүүдийн судалгааны дүнд шинжилгээ, дүгнэлт хийх чадварыг нэмэгдүүлэх

Агуулга

"Хүүхэд, хөгжил -2000" судалгааны асуулгын хуудасны ерөнхий загварыг НҮБ-ын Хүүхдийн сангаас зөвлөмж болгон гаргасан Олон үзүүлэлтүүдийн бүлгийн түүвэр судалгааны асуулгын загварыг үндэслэн өөрийн орны онцлогийг тусган боловсруулав. "Хүүхэд, хөгжил 2000" судалгааны асуулгын хуудсууд нь өрхийн асуулга, 15-49 насны эмэгтэйчүүдийн асуулга, тав хүртэлх насны хүүхдийн асуулгуудаар мэдээллийг цуглуулах зорилгоор боловсруулагдсан.

Өрх: Өрхийн ам бүл, гишүүдийн нас, хүйс, бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшин, гэрлэлтийн байдал, хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, өнчин болон тахир дутуу хүүхэд, өрхийн сууцны төхөөрөмжлөлт, ундны усны болон ариун цэврийн байгууламжийн хангамж мөн йоджуулсан давсны хэрэглээ

15-49 насны эмэгтэйчүүд: Эмэгтэйчүүдийн талаархи мэдээлэл,хүүхдийн эндэгдэл,эх, нярайн эрүүл мэнд,жирэмслэлтээс сэргийлэх арга, хэрэгслийн хэрэглээ,ДОХ/ ХДХ -ын нянгийн халдвар,"Д" амин дэмийн дутагдал

Тав хүртэлх насны хүүхэд: Хүүхдийн төрсөний бүртгэл, сургуулийн өмнөх боловсрол олголт, "А" амин дэмийн хэрэглээ, хөхөөр хооллолт, хүүхдийн өвчлөл, эмчилгээ, сувилгаа, халдварт шар өвчин, урьдчилан сэргийлэх тарилганд хамрагдалт, хүүхдийн биеийн хэмжээс

External Resource хэсэгт байгаа "Хүүхэд хөгжил -2000" судалгааны Үндэсний тайлангаас судалгааны талаарх

дэлгэрэнгүй мэдээллийг авч болно.

МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ

Sample survey data [ssd]

СУДАЛГААНЫ НЭГЖ

- Өрх (өрх-нэг сууцанд хамтран амьдарч, орлогоо нэгтгэн, хамтран хооллож, хувцаслаж байгаа нэг болон хэсэг хүмүүс)

- Өрхийн гишүүд

- 15-49 насны эмэгтэйчүүд

- 0-4 насны хүүхдүүд

Хүрээ

ТЭМДЭГЛЭЛҮҮД

Олон үзүүлэлтүүдийн бүлгийн түүвэр судалгаа, "Хүүхэд, хөгжил -2000" судалгаа нь дараах мэдээллүүдийг аулсан байдаг.

Өрхийн асуулга:

- Өрхийн ам бүл, гишүүдийн нас, хүйс,

- Бичиг үсгийн мэдлэг,

- Боловсролын түвшин,

- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт,

- Өнчин болон тахир дутуу хүүхэд,

- Өрхийн сууцны төхөөрөмжлөлт, ундны усны болон ариун цэврийн байгууламжийн хангамж

- Йоджуулсан давсны хэрэглээ

15-49 насны эмэгтэйчүүдийн асуулга:

-Эмэгтэйчүүдийн талаархи мэдээлэл

-Хүүхдийн эндэгдэл

-Эх, нярайн эрүүл мэнд

-Жирэмслэлтээс сэргийлэх арга, хэрэгслийн хэрэглээ

-ДОХ/ ХДХ -ын нянгийн халдвар

- "Д" амин дэмийн дутагдал.

Тав хүртэлх насны хүүхдийн асуулга:

- Хүүхдийн төрсөний бүртгэл,

- Сургуулийн өмнөх боловсрол олголт,-

- "А" амин дэмийн хэрэглээ,

- Хөхөөр хооллолт,

- Хүүхдийн өвчлөл, эмчилгээ, сувилгаа,
- Халдварт шар өвчин,
- Урьдчилан сэргийлэх тарилганд хамрагдалт,
- Хүүхдийн биеийн хэмжээс

Ажиглалтын хүрээ

ГАЗАР ЗҮЙН ХҮРЭЭ

Энэхүү судалгаа нь 6 бүс (Баруун, Дундад, Төв -1, Дорнод, Өмнөд, Төв -2) нутгийн төлөөлөлтэй Монголын бүх нутгийг хамарсан үндэсний хэмжээний судалгаа юм.

Баруун бүс (Увс, Завхан, Говь-Алтай, Баян-Өлгий, Ховд аймаг)

Дундад бүс (Архангай, Хөвсгөл, Баянхонгор, Өвөрхангай, Булган аймаг)

Дорнод бүс (Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймаг)

Өмнөд бүс (Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говь-Сүмбэр аймаг)

Төвийн 1-р бүс (Төв, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон аймаг)

Төвийн 2-р бүс (Улаанбаатар хот)

ХҮРЭЭ

Судалгааны судлах зүйлсийн дагуу судалгаанд хамрагдсан өрхийн гишүүд, өрхийн 15-49 насны эмэгтэйчүүд, 5 хүртэлх насны хүүхдүүдийг хамруулав

Гүйцэтгэгч болон түнш

АНХНЫ ШИНЖЭЭЧ

Нэр	Харьяалал
Үндэсний Статистикийн Хороо	Улсын Их Хурал

БУСАД ГҮЙЦЭТГЭГЧ

Нэр	Харьяалал	Үүрэг
НҮБ-н Хүүхдийн сан, Монгол улс	НҮБХС	Техникийн зөвлөгч

САНХҮҮЖИЛТ

Нэр	Товчлол	Үүрэг
НҮБ-н Хүүхдийн сан	НҮБХС	Санхүүжүүлэгч

Мета мэдээлэл боловсруулалт

БОЛОВСРУУЛСАН

Нэр	Товчлол	Харьяалал	Үүрэг
Намжилсүрэнгийн Уянга		ҮСГ	Баримтжуулалт хийсэн

МЕТА МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛСАН ОГНОО

2008-01-24

DDI БИЧИГ БАРИМТЫН ХУВИЛБАР

хувилбар 3.0

DDI БИЧИГ БАРИМТЫН ДУГААР

DDI-MNG-NSO-MN-MICS2000-v3.0

Түүвэрлэлт

Түүвэрлэлт

"Хүүхэд, хөгжил -2000" судалгаагаар судалсан үндсэн үзүүлэлтүүдийн улсын дүнгийн төлөөлөх чадварыг 95 хувь, түүврийн алдааны магадлалын хэлбэлзлийг 5 хувиас хэтрэхгүй байхаар тооцоолж түүврийн загварыг боловсруулав. Монгол Улс нь нийгэм, эдийн засгийн хөгжил, газар зүйн байдлын хувьд харилцан адилгүй өргөн уудам нутагтай учир судалгааны үр дүнгийн боловсруулалтыг 6 бүс нутаг болон хот, хөдөөгөөр ангилан хийв. Энэ тохиолдолд ангилал тус бүрээр боловсруулалтын дүнгийн алдааны магадлалын хэлбэлзлийн хэмжээ нь улсын дундаж түвшингээс арай их байж болно.

Түүврийн хэмжээ нь "Хүүхэд, хөгжил -2000" судалгааны зааварт өгөгдсөн тусгай томъёоны дагуу тодорхой түвшний нарийвчлалтайгаар тодорхойлогдсон. "Хүүхэд, хөгжил -2000" судалгаа нь судалгааны тодорхой хэсгээс мэдээллийг олон үзүүлэлтүүдээр цуглуулах зорилготой байсан учир тухайлан сонгож авсан үзүүлэлт болон судлагдах хэсгийн хосолмол байдлыг тодорхой түвшний нарийвчлалтайгаар илэрхийлэх боломжтой өрхийн тоог үндэслэж түүврийн хэмжээг тогтоов. Манай судалгааны түүврийн хэмжээг тодорхойлоход улаанбурханы эсрэг тарилганд хамрагдсан 12-23 сартай хүүхдүүдийн хамрагдалтын түвшинг гол үзүүлэлт болгон авсан. Судалгааны үр дүнгийн хувьд түүврийн төлөөлөх чадвар улсын түвшинд 95 хувь, түүврийн алдааны магадлалын хэмжээг 5 хувиас хэтрүүлэхгүй байх тохиолдолд энэ судалгааны бүх үзүүлэлтүүдээр мэдээллийг 6000 өрхөөс цуглуулах нь тохиромжтой хэмжээ гэж үзэв.

"Хүүхэд, хөгжил -2000" судалгааны ажлыг зохион байгуулагч, төлөвлөгчид нь судалгааны баг тус бүр өдөрт дунджаар 20 өрхөөс ярилцлага авахаар төлөвлөсөн. Энэ тохиолдолд түүврийн нэгж бүлэг нь 20 өрхөөс бүрдсэн нийт 300 бүлэгт хамаарах 6000 өрхөөс ярилцлага авах хэрэгтэй байсан. Судалгааны түүвэрлэлтийг 2 үе шаттайгаар хийсэн. Эхний шатанд Монгол Улсын хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүнг үндэслэн тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийг 6 бүс нутгаар аймаг, сум, баг бүрээр хот, хөдөөгөөр ангилсан жагсаалтаас тооллогын нутаг дэвсгэрээр 300 бүлгийг түүвэрлэн авахаар төлөвлөж, өрхийн нийт дүнд шууд пропорциональ хамааралтайгаар түүврийн 300 бүлгийг сонгов. Түүвэрлэлтийн хоёр дахь шатанд тооллогын нутаг дэвсгэрийн нэгжийг үндэслэн сонгогдсон түүврийн бүлэг тус бүрийг дунджаар 20 орчим тооны өрхтэй сегментүүдэд хуваасан. Энэхүү сегментүүдийн нэг нь санамсаргүйгээр судалгааны нэг бүлэг болон сонгогдсон юм. Сонгогдсон бүлгийн өрх бүр судалгаанд бүрэн хамрагдсан болно.

Түүврийн ангилал: Түүвэрлэлтэнд 2 төрлийн ангилалыг хэрэглэв. Үүнд:

Бүс нутгийн ангилал: Энэхүү тайланд хавсрагдсан хүснэгтүүдийн боловсруулалтыг Баруун, Дундад, Дорнод, Өмнөд, Төвийн 1, Төвийн 2 дугаар бүс гэсэн 6 бүс нутгаар ангилж хийв. Бүс нутгийн энэ ангилал нь Засгийн Газраас мөрдөж байгаа шатахууны үнийн бүс болно. Үүнд:

Баруун бүс (Увс, Завхан, Говь-Алтай, Баян-Өлгий, Ховд аймаг)

Дундад бүс (Архангай, Хөвсгөл, Баянхонгор, Өвөрхангай, Булган аймаг)

Дорнод бүс (Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймаг)

Өмнөд бүс (Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говь-Сүмбэр аймаг)

Төвийн 1-р бүс (Төв, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон аймаг)

Төвийн 2-р бүс (Улаанбаатар хот)

Хот, хөдөөгөөр: Мөн тайланд хавсрагдсан хүснэгтүүдийн боловсруулалтыг дээрхи бүс нутгаар ангилахын зэрэгцээ хот, хөдөөгөөр ангилан боловсруулав. Үүнд:

"Хот" гэсэн ангилалд нийслэл хот, аймгийн төвийн өрх, хүн ам;

"Хөдөө" гэсэн ангилалд сумдын (сумын төв, хөдөөгийн) өрх, хүн амыг тус тус хамруулав.

Судалгааны түүвэрлэлтийн нэгж: Өрх нь судалгааны нэгж болно.

Түүврийн хэлбэлзэл

Монгол Улсын "Хүүхэд, хөгжил -2000" судалгааны түүвэрт сонгож авсан 6000 өрх ярилцлаганд бүрэн хамрагдав

Хамралтын түвшин

Судалгааны түүвэрт сонгож авсан 6000 өрх ярилцлаганд бүрэн хамрагдсан. Энэхүү ярилцлаганд хамрагдсан өрхүүдэд судалгаанд хамрагдвал зохих 15-49 насны 8606 эмэгтэйчүүд бүртгэгдсэнээс 8257 нь ярилцлаганд амжилттай оролцож, хамралтын түвшин 95.9 хувь байна. Мөн судалгаанд хамрагдсан өрхийн асуулгын жагсаалтанд 5 хүртэлх насны 6199 хүүхэд бүртгэгдсэнээс 6184 хүүхэд асуулганд хамрагдаж, хамралтын түвшин 99.8 хувь байна.

Түүврийн жин

Судалгааны мэдээллийн файл бүрт түүврийн жин тооцсон.

Өрхийн мэдээллийн файлын хувьд түүврийн жинг өрхийн сонгогдох магадлалын эсрэг магадлалаар түүврийн бүлэг (бүс бүрийн хувьд хот, хөдөө) бүрийн хувьд тооцсон. Өрхийн асуулгад хариулт өгөөгүй түвшинг засварлах үүднээс өрхийн түүврийн жинг түүврийн бүлэг бүрийн хувьд засварласан ба нийт жинлэгдсэн өрхийн тоог жинлэгдээгүй өрхийн тоотой тэнцүү байлгах үүднээс түүврийн жинг тогтмол тоогоор үржүүлж нормчилсон. Өрхийн түүврийн жингийн хувьсагчийг HHWEIGHT гэж нэрлэсэн ба үүнийг өрхийн мэдээллийн файл - HH, өрийн гишүүдийн мэдээллийн файл - HL тус бүрт ашигласан.

Эмэгтэйчүүдийн мэдээллийн файлын хувьд нормчлоогүй өрхийн түүврийн жинг ашигласан. Эмэгтэйн ганцаарчилсан асуулгад хариулт өгөөгүй түвшинг засварлах үүднээс эмэгтэйн түүврийн жинг түүврийн бүлэг бүрийн хувьд засварласан ба нийт жинлэгдсэн эмэгтэйн тоог жинлэгдээгүй эмэгтэйн тоотой тэнцүү байлгах үүднээс түүврийн жинг тогтмол тоогоор үржүүлж нормчилсон.

Хүүхдийн мэдээллийн файлын хувьд мөн нормчлоогүй өрхийн түүврийн жинг ашигласан. Хүүхдийн асуулгад хариулт өгөөгүй түвшинг засварлах үүднээс хүүхдийн түүврийн жинг түүврийн бүлэг бүрийн хувьд засварласан ба нийт жинлэгдсэн хүүхдийн тоог жинлэгдээгүй хүүхдийн тоотой тэнцүү байлгах үүднээс түүврийн жинг тогтмол тоогоор үржүүлж нормчилсон.

The Mongolia MICS survey sample is approximately self-weighting. Normalized (standardized) sample weights were calculated, however, to reflect differential response rates across sampling domains and small differences in sampling fractions across the domains.

The major component of the weight is the reciprocal of the sampling fraction employed in selecting the number of sample households in that particular sampling domain.

After the completion of fieldwork, response rates were calculated for each sampling domain. There were used to adjust the sample weights calculated for each cluster.

The adjustment for household non-response is equal to the inverse value of

$$RR = \text{Number of interviewed households} / \text{Number of occupied households listed}.$$

Similarly, the adjustment for non-response at the individual level (women aged 15-49 years and children aged under-five) is equal to the inverse value of

$$RR = \text{Completed women's (or under-5's) questionnaires} / \text{Eligible women (or under-5s)}.$$

Numbers of eligible women and under-5 children were obtained from the household listing in the Household Questionnaire in households where interviews were completed.

The unadjusted weights for the households were calculated by multiplying the above factors for each PSU. These weights were then standardized (or normalized), one purpose of which is to make the sum of the interviewed sample units equal the total sample size at the national level. Normalization is performed by multiplying the aforementioned unadjusted weights by the ratio of the number of completed households to the total unadjusted weighted number of households. A similar standardization procedure was followed in obtaining standardized weights for the women's and under-5's questionnaires.

Асуулгууд

Тойм

"Хүүхэд, хөгжил -2000" судалгааны асуулгын хуудасны ерөнхий загварыг НҮБ-ын Хүүхдийн сангаас зөвлөмж болгон гаргасан Олон үзүүлэлтүүдийн бүлгийн түүвэр судалгааны асуулгын загварыг үндэслэн өөрийн орны онцлогийг тусган боловсруулав. "Хүүхэд, хөгжил 2000" судалгааны асуулгын хуудсууд нь судалгааны тодорхой хэсэг бүрээс тусгай асуултуудаар мэдээллийг цуглуулах зорилгоор боловсруулагдсан. Түүвэр судалгааны асуулгын хуудас нь үндсэн 3 төрлийн асуулгын маягтаас бүрдэх ба асуулгын маягт бүр нь хэд хэдэн дэд бүлгүүдээс бүрдэнэ.

Түүвэр судалгааны асуулгын хуудсууд:

Өрхийн асуулга: Өрхийн ам бүл, гишүүдийн нас, хүйс, бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшин, гэрлэлтийн байдал, хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, өнчин болон тахир дутуу хүүхэд, өрхийн сууцны төхөөрөмжлөлт, ундны усны болон ариун цэврийн байгууламжийн хангамж мөн йоджуулсан давсны хэрэглээний талаархи мэдээллийг цуглуулна.

15-49 насны эмэгтэйчүүдийн асуулга:

Дараахи дэд бүлгүүдээс бүрдэнэ. Үүнд:

Эмэгтэйчүүдийн талаархи мэдээлэл

Хүүхдийн эндэгдэл

Эх, нярайн эрүүл мэнд

Жирэмслэлтээс сэргийлэх арга, хэрэгслийн хэрэглээ

ДОХ/ ХДХ -ын нянгийн халдвар

"Д" амин дэмийн дутагдал.

Тав хүртэлх насны хүүхдийн асуулга: Хүүхдийн төрсөний бүртгэл, сургуулийн өмнөх боловсрол олголт, "А" амин дэмийн хэрэглээ, хөхөөр хооллолт, хүүхдийн өвчлөл, эмчилгээ, сувилгаа, халдварт шар өвчин, урьдчилан сэргийлэх тарилганд хамрагдалт, хүүхдийн биеийн хэмжээс гэсэн дэд бүлгүүдээс бүрдэнэ.

Энэ судалгааг зохион явуулах ажлын хэсэг нь удирдлагын зөвлөлийн зохицуулалттайгаар судалгааны энэхүү асуулгын хуудасны маягт, зааврыг боловсруулсан. Асуулгын загварын Англи хувилбарыг Монгол хэл рүү хөрвүүлж, улмаар боловсронгуй болгон сайжруулсаны дараа ажлын хэсгийнхнээр дамжуулан Засгийн Газрын болон Засгийн Газрын бус холбогдох байгууллагуудаас (тухайлбал: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам, Хүүхдийн төлөө үндэсний төв, Цагдаагийн ерөнхий газар, Хүүхдийн эрхийн төв) авсан саналыг уг асуулганд тусган боловсруулалтыг дахин хийсэний дараа асуулгын хуудас, түүнийг нөхөх зааврыг хот, хөдөөгийн тодорхой тооны өрх дээр туршсан. Туршилтын дүнд асуулгын хуудсанд байгаа асуултуудын утгыг хариулагчид ойлгомжтой байлгахаар үг, үсгийг өөрчлөх, асуултуудын хоорондын логик уялдаа, дараалалтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэсэний зэрэгцээ нэг өрхөөс ярилцлага авах дундаж хугацааг 90 минут байхаар тогтоож, судалгааны ярилцлага авах, мэдээлэл цуглуулах нийт хугацааг тодорхойлов. Туршилтын явцад гарсан асуудлуудыг бүрэн шийдэж, судалгааны асуулгын хуудас, түүнийг нөхөх зааврыг эцэслэн боловсруулаад ҮСГ-ын холбогдох шатны удирдлага, зөвлөлүүд дээр хэлэлцүүлж, Удирдлагын зөвлөлөөр батлуулсан.

External resources хэсгээс асуулгын хуудсыг дэлгэрэнгүй харж болно.

Мэдээлэл цуглуулалт

Мэдээлэл цуглуулалтын огноо

Эхлэх	Дуусах	Цикл
2000-05	2000-08	N/A

Мэдээлэл цуглуулалтын бодлого

Face-to-face [f2f]

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫН ТЭМДЭГЛЭГЭЭ

"Хүүхэд, хөгжил - 2000" судалгааг хариуцан явуулах албан ёсны гэрээг Үндэсний статистикийн газар болон НҮБ-ын Хүүхдийн Сангийн Монгол улс дахь суурин төлөөлөгчийн газрын удирдлагуудын хүрээнд 2000 оны 5 дугаар сард албан ёсоор байгуулав.

Судалгааг удирдан явуулах удирдлагын зөвлөл болон ажлын хэсэг дээр тохирсоны дагуу НҮБ-ын Хүүхдийн сангийн бүсийн байгууллагаас өгсөн зааврыг үндэслэн судалгааны ажилтангуудыг шалгаруулан авч тусгай сургалтанд хамруулсан. Судалгааны мэдээлэл цуглуулах 8 багийг тус бүр 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж, баг бүрт нэг ахлагч, хянагч 2, ярилцлага авагч 4, хоёр жолооч ажиллав. Багийн ахлагч нар нь судалгааны ажлын хэсгийн байнгын удирдлагын дор багийн хамт олныг өдөр тутмын ажлаар хангаж, хянагч нар нь тухайн өдрийн цуглуулсан мэдээллийг шалган хүлээн авч, алдаатай, бүрэн бус, тодорхойгүй зүйлийг илрүүлэн газар дээр нь тодруулж, залруулгыг хийлгэж байв. Энэ судалгааны мэдээлэл цуглуулах шатны ажил нь Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн ажилтай цаг хугацааны хувьд давхцаж байсан нь бидний ажилд нилээд хүндрэлийг учруулах магадлал өндөртэй байсан юм. Иймээс статистикийн орон нутгийн байгууллагын ажилтныг аймаг, хотын удирдлагатай зөвшилцсөний үндсэн дээр үндсэн ажлаас нь нэг сарын хугацаатайгаар цалингүй чөлөөлж мэдээлэл цуглуулах багийн нэг хянагчаар ажиллуулсан нь мэдээлэл цуглуулах ажлыг орон нутагт ямар нэг хүндрэлгүйгээр зохион байгуулах, цуглуулсан мэдээллийн үнэн зөв байдал болон түүврийн бус алдааг багасгах, улмаар мэдээллийг компьютерт бэлтгэх хугацааг богиносгоход зохих нөлөө үзүүлсэн.

Өрхөөс мэдээлэл цуглуулах үе шатны ажил нь 2000 оны 5 дугаар сарын сүүлчээр эхлэж, 2000 оны 8 дугаар сарын эхээр дууссан.

Судалгааны удирдлагын зөвлөл, ажлын хэсгийн гишүүдээс бүрдсэн хяналтын 4 баг мэдээлэл цуглуулах болон ярилцлага авагч, хянагч нарын ажлын явцыг нийт 10 аймаг, Улаанбаатар хотод хянаж, шалган, гарсан дутагдал, ололтыг тухай бүр нь танилцуулж, шаардлагатай арга хэмжээг авч ажилласан. Мэдээлэл цуглуулах ажил нь 3 үе шаттай явагдав. Мэдээлэл цуглуулах баг нь эхний аймгаас Улаанбаатар хотод буцаж ирэнгүүт цуглуулсан мэдээллээ "Мэдээллийг хүлээн авч компьютерт бэлтгэх ажлын хэсэгт" хуваарийн дагуу бүрэн хүлээлгэн өгсөний дараа дараагийн аймагт явах зөвшөөрлийг хүлээн авах журмаар ажиллав. Ингээд мэдээлэл цуглуулах баг тус бүр 2 аймагт ажиллаж, улмаар гурав дахь ээлжинд бүх багууд Улаанбаатар хотод ажилласан.

Мэдээлэл цуглуулалт

Нэр	Товчлол	Харьяалал
Статистикийн Үндэсний газар, Монгол улс	ҮСГ	

SUPERVISION

Судалгааны мэдээлэл цуглуулах 8 багийг тус бүр 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж, баг бүрт нэг ахлагч, хянагч 2, ярилцлага авагч 4, хоёр жолооч ажиллав. Багийн ахлагч нар нь судалгааны ажлын хэсгийн байнгын удирдлагын дор багийн хамт олныг өдөр тутмын ажлаар хангаж, хянагч нар нь тухайн өдрийн цуглуулсан мэдээллийг шалган хүлээн авч, алдаатай, бүрэн бус, тодорхойгүй зүйлийг илрүүлэн газар дээр нь тодруулж, залруулгыг хийлгэж байв. Статистикийн орон нутгийн байгууллагын ажилтныг аймаг, хотын удирдлагатай зөвшилцсөний үндсэн дээр үндсэн ажлаас нь нэг сарын хугацаатайгаар цалингүй чөлөөлж мэдээлэл цуглуулах багийн нэг хянагчаар ажиллуулсан нь мэдээлэл цуглуулах ажлыг орон нутагт ямар нэг хүндрэлгүйгээр зохион байгуулах, цуглуулсан мэдээллийн үнэн зөв байдал болон түүврийн бус алдааг багасгах, улмаар мэдээллийг компьютерт бэлтгэх хугацааг богиносгоход зохих нөлөө үзүүлсэн. Судалгааны удирдлагын зөвлөл, ажлын хэсгийн гишүүдээс бүрдсэн хяналтын 4 баг мэдээлэл цуглуулах болон ярилцлага авагч, хянагч нарын ажлын явцыг нийт 10 аймаг, Улаанбаатар хотод хянаж, шалган, гарсан дутагдал, ололтыг тухай бүр нь танилцуулж, шаардлагатай арга хэмжээг авч ажилласан.

Мэдээлэл боловсруулалт

Мэдээлэл засалт

Судалгааны мэдээллийг бэлтгэх ISSA программ хангамжийг ашиглан судалгааны өрхийн мэдээллийг жижиг оврын 5 компьютерт бэлтгэн оруулсан. Мэдээллийг компьютерт бэлтгэн оруулах операторчдыг хөлслөн ажиллуулсан бөгөөд тэднийг 4 өдрийн сургалтанд хамруулсан. Мэдээллийг боловсруулах ажлын баг нь мэдээллийн бүрдэлтийг шалган хүлээн авах, хянах, боловсруулалтанд бэлтгэж, компьютерт оруулах, шалгалтын программыг боловсруулж, ажиллуулж, алдааны протокол хэвлэн гаргах, алдааны засварлагдсан протоколыг дахин компьютерт оруулах, НҮБ-ын хүүхдийн сангийн бүсийн байгууллагаас өгсөн программ хангамжийг хөрвүүлэх, шаардлагатай нэмэлт программыг бичиж, зааврын дагуу боловсруулалтыг хийх үндсэн үүргийг гүйцэтгэв. Мэдээллийн чанарыг баталгаажуулахын тул бүх асуулгын хуудасны мэдээллийг компьютерт 2 удаа бэлтгэн оруулж ерөнхий дүн тохирч буйг хянаж шалгасан. Мэдээллийг боловсруулах багийн ахлагч, программ зохиогч нар 2000 оны 4 дүгээр сард Бангкокт зохион байгуулагдсан уг судалгааны "Мэдээллийг боловсруулах сургалт"-нд хамрагдаж, асуулгын загвар болон мэдээллийг компьютерт бэлтгэн оруулах, хянах, засварлах, боловсруулах, нэгдсэн дүнг гарган авах программ болон статистик анализид өргөн хэрэглэдэг SPSS программ хангамжийг энэхүү судалгаанд хэрхэн ашиглах талаар мэдлэг чадвараа дээшлүүлсэн юм. Улмаар "Хүүхэд, хөгжил-2000" судалгааны хүрээнд өөрийн улсын онцлогт тохирсон асуулгын хуудасны дагуу дээрхи бүх төрлийн программуудад нэмэлт боловсруулалт, өөрчлөлтийг хийж ашиглав.

Өрхөөс ярилцлага хийж цуглуулсан мэдээллийг компьютерт бэлтгэх, шалгах, засварлах, боловсруулах ажлыг 2000 оны 7-9 дүгээр сард гүйцэтгэсэн нь уг ажлыг технологийн дагуу төлөвлөсөн хугацаанаас маш богино хугацаанд гүйцэтгэсэн болно. Мэдээллийг шалгаж, боловсруулж, хянаж, бэлтгэн оруулах үеэр "Хүүхэд, хөгжил-2000" судалгааны ажлын хэсэг нь судалгааны бүсийн байгууллагын холбогдох ажилтангуудтай ажлын байнгын ойр холбоотой ажиллаж, программ хангамж, математик томъёоллын талаар гарч байсан асуудлууд, бэрхшээлийг хялбархан шийдвэрлэж байв.

Мэдээллийн боловсруулалтыг судалгааны асуулгын хуудсыг үндэслэн өгөгдсөн программ хангамжийг ашиглан хийсэн. "Хүүхэд, хөгжил -2000" судалгааны боловсруулалтын ажлыг анхны ба хоёрдогч гэсэн 2 үе шаттай явуулав. Мэдээлэл боловсруулалтын эхний шатны зорилго нь мэдээллийг боловсруулах технологийн дарааллыг нарийн мөрдөж алдаагүй эх файлыг бэлтгэн авах асуудал байсан. Үүнд:

- 1.1 Мэдээллийг компьютерт оруулах
- 1.2 Мэдээллийн бүтцийг шалгах
- 1.3 Нягталж шалгах
- 1.4 Дахин хянаж, шалгах
- 1.5 Баталгаажсан мэдээллийн файл үүсгэх

Мэдээллийг боловсруулах 2 дахь шатанд хүснэгт бүхий файлыг дүн шинжилгээнд ашиглахад зориулан боловсруулан гаргах явдал байлаа. Мэдээллийг боловсруулах 2 дахь шат нь дараах үе шатуудаас бүрдэнэ:

- 2.1 Хувилбаруудыг оруулах
- 2.2 Үр дүнгийн хүснэгтүүдийг боловсруулж бэлэн болгох

Энэхүү түүвэр судалгааны мэдээллийг боловсруулж дууссаны дараа статистикийн мэргэжлийн хүмүүс тодорхой үзүүлэлтүүд дээр статистикийн дүн шинжилгээ хийж, судалгааны боловсруулалтын үр дүнгийн үндсэн үзүүлэлтүүдийг бусад эх сурвалжаас авсан мэдээлэлтэй харьцуулж үзэх, боловсруулалтын үр дүнг хянах, илэрсэн алдааг засварлах, зарим үзүүлэлтийн боловсруулалтанд хэрэглэсэн томъёолол, агуулгыг лавлан тодруулсаны үндсэн дээр ажлын баримт бичиг болох материалуудыг бэлтгэн гаргаж цаашдын судалгаа хийх, тайлан бичихэд хэрэглэв. Үүнд: статистикийн албан ёсны бусад мэдээллүүд, үзүүлэлтүүдийн олон жилийн динамик, хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүн гэх мэт мэдээллийн эх үүсвэрүүдийг ашигласан болно.

"Хүүхэд, хөгжил -2000" судалгааны үйл ажиллагааны хүрээнд "Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн талаархи нэлэнхүй ажиглалтын судалгаа"-г Монгол Улсын засаг захиргааны бүх нэгжүүдээс 2000 оны 8-9 дүгээр сард цуглуулсан. Судалгааны асуулгын хоёрдугаар маягтаар (ХХС-2) цуглуулсан энэхүү мэдээллийн боловсруулалтанд зориулж мэдээллийг бэлтгэх, шалгах, боловсруулах программ, түүний нэгдсэн заавар аргачлалыг тусгайлан боловсруулж, судалгааг зохион явуулах ажлын хэсэг, удирдлагын зөвлөлөөр хянан баталгаажуулж улмаар боловсруулалтыг үйлдвэрлэлд шилжүүлсэн. Судалгааны энэхүү асуулгын дагуу "Хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн талаар" нилээд дэлгэрэнгүй мэдээллийн санг бүрдүүлэв.

Мэдээллийг боловсруулж дууссаны дараа судалгааны мэдээлэл цуглуулсан асуулгын хуудсууд бүхий эх мэдээллүүдийг архивт шилжүүлж, судалгааг хэрхэн явуулсантай холбогдсон техникийн тайланг тусад нь бэлтгэсэн болно.

Бусад боловсруулалт

Тайланд тусгагдаагүй.

Мэдээллийн үнэлэлт

Мэдээлэл үнэлэлтийн бусад хэлбэр

Судалгаагаар цуглуулсан мэдээллийн чанарыг тодорхойлох гол үзүүлэлт бол сонгож авсан асуулгын дагуу огт авч чадаагүй болон бүрэн бус авсан мэдээллийн эзлэх хувийн жин юм. Бүрэн бус мэдээллийн талаар Хүснэгт 3-аас харж болно. Сонгож авсан асуулганд хамрагдсан 21230 гишүүдийн 8.3 хувь нь буюу 1764 хүн боловсролын түвшингийн талаар мөн 0.1 хувь нь буюу 12 гишүүн сургуульд суралцаж байгаа, эсэх талаар бүрэн бус мэдээлэл өгсөн эсвэл мэдээлэл огт өгөөгүй байна. Эмэгтэйчүүдийн асуулгын хариултын дунд судалгаанд хамрагдсан төрөх насны 8257 эмэгтэйн 9 нь буюу 0.1 хувь нь төрсөн он, сар, өдрөө мөн ДОХ/ ХДХ-ын нянгийн халдварын сорил хийлгэсэн, эсэх талаархи асуулгын хариултыг огт өгөөгүй буюу бүрэн бус мэдээлэл өгсөн байв. Хүүхдийн судалгаанд хамрагдсан тав хүртэлх насны 6184 хүүхдүүдээс сүүлийн 14 хоногт суулгалт өвчнөөр өвчилсөн тухай асуултын хариултыг 5 хүүхдээс бүрэн аваагүй байв. Мөн 253-254 хүүхдийн биеийн өндөр, урт болон жинг хэмжсэн талаархи мэдээллийг бүрэн бус буюу огт аваагүй нь энэ насны хүүхдүүдийн 4.1 хувь болж байна. Эдгээр бүрэн бус мэдээллийн эзлэх хувийн жинг олон улсын стандарт хэмжээтэй харьцуулан үзэхэд харьцангуй бага байна. /Саммерпелт, Воерма. 1994/.

Файлын тайлбар

variable_list

Household

Агуулга	Өрхийн мэдээлэл агуулсан мэдээллийн бааз.(ОУБТС-2 Өрхийн асуулга, Өрхийн мэдээлэл,Хаягийн хэсэг, Ундны болон ариун цэврийн байгууламжийн хангамж , Өрхийн ам бүлийн байдал Өрхийн гишүүдийн боловсролын байдал,Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт,Эхийн эндэгдэл,Тахир дутуу хүүхэд ба and Иоджуулсан давсны хэрэглээ)
Тохиолдолууд	6000
Хувьсагч	53
Бүтэц	Төрөл: relational Түлхүүрүүд: hi1(Түүврийн бүлгийн дугаар), hi2(Өрхийн дугаар)
Хувилбар	Хувилбар 2.0: Үндэсний тайланд тусгагдсан засварлагдсан мэдээллийн бааз
Гүйцэтгэгч	Үндэсний статистикийн газар,Монгол улс, НҮБ-н Хүүхдийн сан
Missing Data	

Хувьсагчид

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн	Асуулт
V254	hi1	Түүврийн бүлгийн дугаар	discrete	numeric	
V255	hi2	Өрхийн дугаар	discrete	numeric	
V256	hi3d	Судалгаа авсан өдөр	contin	numeric	
V257	hi3m	Судалгаа авсан сар	contin	numeric	
V258	hi3y	Судалгаа авсан он	contin	numeric	
V259	hi4	Тоологчийн хувийн дугаар	discrete	numeric	
V260	hi6	Өрхийн байршил	discrete	numeric	
V261	hi7	Нийслэл, аймгийн нэр	discrete	numeric	
V262	hi8a	Сууцны төрөл	discrete	numeric	Танай сууцны төрөл?
V263	hi8b	Өмчийн хэлбэр:	discrete	numeric	Танай сууцны өмчийн хэлбэр?
V264	hi8c	Сууцны талбай	discrete	numeric	Танай сууцны талбай хэд вэ(м.кв)?
V265	hi8d	Байшингийн ханын материал	discrete	numeric	Танай байшингийн ханын материал юу?
V266	hi8e	Сууцны шалны үндсэн материал	discrete	numeric	Танай сууцны шалны үндсэн материал юу?
V267	hi8f	Өрөөний тоо	contin	numeric	Танай байшин хэдэн өрөөтэй вэ?
V268	hi8h	Гэрийн ханын тоо	contin	numeric	Танай гэр хэдэн ханатай вэ?
V269	hi9a	Халаалтын төрөл	discrete	numeric	Танай өрхийн эзэмшиж байгаа сууцны халаалтын хангамж, төхөөрөмжлөлтий төрөл?
V270	hi9b	Түлшний төрөл	discrete	numeric	Танайх хоол ундаа хийхдээ ямар түлш хэрэглэдэг вэ?
V271	hi9c1	Цахилгаан	discrete	numeric	Танайх цахилгаан гэрэлтэй юу?
V272	hi9c2	Радио	discrete	numeric	Танайд радио бий юу?
V273	hi9c3	Телевизор	discrete	numeric	Танайд телевизор бий юу?
V274	hi9c4	Хөргөгч	discrete	numeric	Танайд хөргөгч бий юу?
V275	hi9d1	Дугуй	discrete	numeric	Танай гэрийн хэн нэгэнд унадаг дугуй бий юу?
V276	hi9d2	Мотоцикл	discrete	numeric	Танай гэрийн хэн нэгэнд мотоцикл бий юу?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн матрица	Асуулт
V277	hi9d3	Суудлын буюу ачааны машин	discrete	numeric	Танайд суудлын буюу ачааны машин бий юу?
V278	hi9e	Амины мал	discrete	numeric	Танайх амины малтай юу ?
V279	hi9f	Хувийн тариалангийн талбай	discrete	numeric	Танайх хувийн тариалангийн талбайтай юу?
V280	hi9h	Өрхийн нэг хүнд ногдох сарын хэрэглээ	contin	numeric	Танай өрхийн нэг хүнд ногдох сарын хэрэглээ хэд вэ?
V281	hi10	Ярилцлагын дүн	discrete	numeric	
V282	hi11	Судалгаанд хамрагдвал зохих эмэгтэйчүүдийн тоо	contin	numeric	Судалгаанд хамрагдвал зохих эмэгтэйчүүдийн тоо?
V283	hi12	Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүд	contin	numeric	Үүнээс судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүд?
V284	hi13	5 хүртэлх насны хүүхдийн тоо	contin	numeric	5 хүртэлх насны хүүхдийн тоо?
V285	hi14	Судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо	contin	numeric	Үүнээс судалгаанд хамрагдсан хүүхэд?
V286	hi15	0-18 насны тахир дутуу хүүхдийн тоо	contin	numeric	0-18 насны тахир дутуу хүүхдийн тоо?
V287	hi16	Судалгаанд хамрагдсан тахир дутуу хүүхэд	contin	numeric	Үүнээс судалгаанд хамрагдсан тахир дутуу хүүхдийн тоо?
V288	himem	Өрхийн ам бүлийн тоо	contin	numeric	Өрхийн ам бүлийн тоо?
V289	ws1	Ундны усны эх үүсвэр	discrete	numeric	Танайх ундны усаа хаанаас авдаг вэ?
V290	ws2	Ундны усаа ус түгэх цэгээс авахад зарцуулдаг цаг	discrete	numeric	Ундны усаа ус түгэх цэгээс авахад хэдэн цаг зарцуулдаг вэ?
V291	ws3	Ариун цэврийн байгууламжийн төрөл	discrete	numeric	Танайх ямар жорлон хэрэглэдэг вэ?
V292	ws4	Ариун цэврийн байгууламжын байрлал	discrete	numeric	Танай ариун цэврийн байгууламж (жорлон)хаанаа байдаг вэ?
V293	ws5	(0-3 насны) хүүхдийн ялгас зайлуулалт	discrete	numeric	Хүүхдүүийн (0-3 насны) ялгасдсыг хаашаа зайлуулдаг вэ ?
V294	si1	Иоджуулсан давсны хэрэглээ	discrete	numeric	Танай хүнсэндээ хэрэглэж буй давсны иоджуулалтыг шалгаж үзье. Танайх ямар иоджуулсан давсны хэрэглэдэг вэ?
V295	totwoman	Энэхүү асуулгад хамарсан 15-49 насны нийт эмэгтэйчүүдийн тоо	contin	numeric	
V296	totkid5	Судалгаанд хамрагдсан 5 болон түүнээс дээш насны хүүхдийн тоо	contin	numeric	
V297	totkid15	Судалгаанд хамрагдсан 15 болон түүнээс дээш насны хүүхдийн тоо	contin	numeric	
V298	hhmember	Өрхийн гишүүдийн тоо	discrete	numeric	
V299	regcode	Бүсийн нэр	contin	numeric	
V300	ur	Харъяалал	contin	numeric	
V301	kid15	15 ба түүнээс дээш насны хүүхэд	contin	numeric	
V302	kid5	5 ба түүнээс дээш насны хүүхэд	contin	numeric	
V303	woman	15-49 насны эмэгтэйчүүд	contin	numeric	15-49 насны эмэгтэйчүүд
V304	k5	5 ба түүнээс дээш насны хүүхэд	contin	numeric	
V305	k15	15 ба түүнээс дээш насны хүүхэд	contin	numeric	
V306	w1	15-49 насны эмэгтэйчүүд	contin	numeric	

Household Roster

Агуулга	Өрхийн мэдээлэл агуулсан мэдээллийн бааз.(ОУБТС-2 Өрхийн асуулга, Өрхийн мэдээлэл,Хаягийн хэсэг, Ундны болон ариун цэврийн байгууламжийн хангамж , Өрхийн ам бүлийн байдал Өрхийн гишүүдийн боловсролын байдал,Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт,Эхийн эндэгдэл,Тахир дутуу хүүхэд ба and Иоджуулсан давсны хэрэглээ)
Тохиолдолууд	29948
Хувьсагч	100
Бүтэц	Төрөл: relational Түлхүүрүүд: hi1(Түүврийн бүлгийн дугаар), hi2(Өрхийн дугаар)
Хувилбар	Хувилбар 2.0: Үндэсний тайланд тусгагдсан засварлагдсан мэдээллийн бааз
Гүйцэтгэгч	Үндэсний статистикийн газар,Монгол улс, НҮБ-н Хүүхдийн сан
Missing Data	

Хувьсагчид

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V307	hi1	Түүврийн бүлгийн дугаар	discrete	numeric	
V308	hi2	Өрхийн дугаар	discrete	numeric	
V309	hl1	Хувийн дугаар	discrete	numeric	
V310	hl2	Өрхийн тэргүүлэгчийн хамаарал	discrete	numeric	Өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай вэ?
V311	hl3	Хүйс	discrete	numeric	Өрхийн гишүүн (нэр)-ий хүйс?
V312	hl4	Нас	contin	numeric	Өрхийн гишүүн (нэр) хэдэн настай вэ?
V313	hl5	15-49 насны нийт эмэгтэйчүүдийн мөрийн дугаар	contin	numeric	15-49 настай эмэгтэй бий юу?
V314	hl6	Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт хэсгийн эх,асрагчийн хувийн дугаар	discrete	numeric	Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт хэсгийн 5-17 насны хүүхдийн эх /асрагч нь хэн бэ?
V315	hl7	Хүүхдийн эрүүл мэндийн хэсгийн эх,асрагчийн хувийн дугаар	discrete	numeric	Хүүхдийн эрүүл мэнд хэсгийн 5 хүртэлх насны хүүхдийн эх /асрагч нь хэн бэ?
V316	hl8	Насанд хүрэгчдийн бичиг үсгийн мэдлэг.	discrete	numeric	Захидал, сонин уншиж чадах уу?
V317	hl9	Гэрлэлтийн байдал	discrete	numeric	Өрхийн гишүүний(нэр)гэрлэлтийн байдал?
V318	hl10	Эх нь амьд, сэрүүн эсэх	discrete	numeric	(Нэр)-ийн төрсөн эх нь амьд, сэрүүн байгаа юу?
V319	hl11	Төрсөн эх нь хамт амьдардаг эсэх	discrete	numeric	Хэрвээ амьд бол (нэр)-ийн төрсөн эх нь хамт амьдарч байна уу?
V320	hl12	Эцэг нь амьд, сэрүүн эсэх	discrete	numeric	(Нэр)-ийн төрсөн эцэг нь амьд, сэрүүн байгаа юу?
V321	hl13	Төрсөн эцэг нь хамт амьдардаг эсэх	discrete	numeric	Хэрвээ амьд бол (нэр)-ийн төрсөн эцэг нь хамт амьдарч байна уу?
V322	ed14	Өрхийн гишүүдийн хувийн дугаар	discrete	numeric	
V323	ed15	Сургуульд суралцаж байгаа эсэх	discrete	numeric	Та сургуульд суралцаж байгаа эсвэл суралцаж байсан уу?
V324	ed16a	Боловсролын түвшин	discrete	numeric	Аль шатны сургууль /анги/ төгссөн бэ ?
V325	ed16b	Ямар анги төгссөн	contin	numeric	Аль шатны сургуулийн ямар анги төгссөн бэ ?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V326	ed17	Цэцэрлэг, сургуульд сурч байгаа эсэх	discrete	numeric	Одоо цэцэрлэг, сургуульд сурч байна уу ?
V327	ed18	Энэ хичээлийн жилд Та цэцэрлэг сургуульд явсан эсэх	discrete	numeric	Энэ хичээлийн жилд Та цэцэрлэг сургуульд явсан уу ?
V328	ed19	Сүүлийн 7 хоногт цэцэрлэг, сургуульд явсан өдөр	contin	numeric	Сүүлийн 7 хоногт хэдэн өдөр цэцэрлэг, сургуульд явсан бэ?
V329	ed20a	Одоо сурч байгаа боловсролын түвшин	discrete	numeric	Хэддүгээр ангид суралцаж байна вэ?
V330	ed20b	Сурч байгаа анги	contin	numeric	Хэддүгээр ангид суралцаж байна вэ?
V331	ed21	Сүүлийн жилд цэцэрлэг, сургуульд явсан эсэх	discrete	numeric	Сүүлийн жилд цэцэрлэг, сургуульд явсан уу ?
V332	ed22a	Сүүлийн жилд аль шатны сургуульд сурч байгаа	discrete	numeric	Сүүлийн жилд аль шатны сургуульд сурч байсан бэ ?
V333	ed22b	Сүүлийн жилд аль шатны сургуулийн хэддүгээр ангид сурч байгаа	contin	numeric	Сүүлийн жилд аль шатны сургуулийн хэддүгээр ангид сурч байсан бэ ?
V334	cl1	Хүүхдийн хувийн дугаар	discrete	numeric	
V335	cl3	Сүүлийн 7 хоногт өрхөөсөө гадуур ажил хийсэн эсэх	discrete	numeric	Сүүлийн 7 хоногт өрхөөсөө гадуур ямар нэг ажил хийсэн үү?
V336	cl3a	Хийсэн ажлын төрөл	discrete	numeric	Хэрвээ ажил хийсэн бол хаана ажил хийсэн бэ?
V337	cl4	Сүүлийн 7 хоногт ажилласан цаг	contin	numeric	Сүүлийн 7 хоногт хэдэн цаг ажилласан бэ?
V338	cl5	Сүүлийн жилд өрхөөсөө гадуур хийсэн ажил	discrete	numeric	Сүүлийн жилд өрхөөсөө гадуур ямар нэг ажил хийсэн үү?
V339	cl5a	Сүүлийн жилд хийсэн ажлын төрөл	discrete	numeric	Хэрвээ ажил хийсэн бол хаана ажил хийсэн бэ?
V340	cl6	Сүүлийн 7 хоногт гэрийнхээ ажилд тусалсан эсэх	discrete	numeric	Сүүлийн 7 хоногт гэрийнхээ ажилд тусалсан уу? (хоол бэлтгэх, худалдан авах, гэрээ цэвэрлэх, хувцас угаах, ус зөөх, түлш бэлтгэх, хүүхэд асрах, г.м)
V341	cl7	Сүүлийн 7 хоногт гэрийн ажилд зарцуулсан цаг	contin	numeric	Гэрийн ажилд сүүлийн 7 хоногт хэдэн цаг зарцуулсан бэ?
V342	cl8	Сүүлийн 7 хоногт өрхийн бизнесийн ажилд тусалсан эсэх	discrete	numeric	Сүүлийн 7 хоногт өрхийн бизнесийн ажилд тусалсан уу?
V343	cl9	Сүүлийн 7 хоногт өрхийн бизнесийн ажилд зарцуулсан цаг	contin	numeric	Сүүлийн 7 хоногт өрхийн бизнесийн ажилд хэдэн цаг зарцуулсан бэ ?
V344	cl10	Бизнесийн төрөл	discrete	numeric	Өрхийн эрхэлдэг бизнесийн төрөл?
V345	mm1	Төлөөлөн хариулж байгаа хүний хувийн дугаарыг	discrete	numeric	
V346	mm3	Итгэмжлэгдсэн хүн	discrete	numeric	Энэ итгэмжлэгдсэн хүн мөн үү?
V347	mm4	Төлөөлөн хариулагчийн хувийн дугаар.	discrete	numeric	Төлөөлөн хариулагчийн хувийн дугаар?
V348	mm5	Та нэг эхээс төрсөн хэдэн эгч, дүүтэй	contin	numeric	Та нэг эхээс төрсөн хэдэн эгч, (эмэгтэй) дүүтэй вэ?
V349	mm6	Та 15 болон түүнээс дээш насны эгч, дүү	contin	numeric	Та 15 болон түүнээс дээш насны хэдэн эгч, дүүстэй вэ?
V350	mm7	Одоо амьд сэрүүн байгаа 15 ба түүнээс дээш настай эгч, дүү	contin	numeric	15 ба түүнээс дээш настай эгч, дүү нараас тань хэд нь одоо амьд сэрүүн байгаа вэ?
V351	mm8	Нас барсан 15 ба түүнээс дээш настай эгч, дүү нарын тоо	contin	numeric	15 ба түүнээс дээш настай эгч, дүү нараас хэд нь нас барсан бэ?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V352	mm9	Төрөхийн улмаас нас барсан эгч дүүгийн тоо	contin	numeric	Нас барсан тэдгээр эгч дүү нарын хэд нь төрөхийн улмаас (жирэмслэлт, эсвэл хүүхэд төрүүлэх болон төрсөний дараахи 6 долоо хоногт) нас барсан бэ?
V353	dm1	Хувийн дугаар	discrete	numeric	
V354	dm3	Оюун ухаан болон бие эрхтний ямар нэгэн согогтой эсэх	discrete	numeric	Танай хүү,охин оюун ухаан болон бие эрхтний ямар нэгэн согогтой юу?
V355	dm4	Бие эрхтний согогтой эсэх	discrete	numeric	Бусад хүүхдүүдтэй харьцуулахад бие эрхтний согогтой юу?
V356	dm5	Өдөр болон шөнийн цагаар харааны согогтой эсэх	discrete	numeric	Өдөр болон шөнийн цагаар харааны согогтой юу?
V357	dm6	Сонсох эрхтний согогтой эсэх	discrete	numeric	Энэ хүүхдэд сонсох эрхтний согогтой юу?
V358	dm7	Оюун ухааны хомсдолтой эсэх	discrete	numeric	Оюун ухааны хомсдолтой юу?
V359	dm8	Заримдаа татаж унаж, ухаан алддаг эсэх	discrete	numeric	Заримдаа татаж унаж, ухаан алддаг уу?
V360	dm9	Байнга эмчилгээ хийлгэдэг эсэх	discrete	numeric	Байнга эмчилгээ хийлгэдэг үү?
V361	dm10	Эмчилгээ үр дүнтэй эсэх	discrete	numeric	Эмчилгээ ямар үр дүнд хүрч байна вэ?
V362	dm11	Хүүхэд цаашид бусдын тусламжгүйгээр амьдарч чадах эсэх	discrete	numeric	Хүүхэд цаашид бусдын тусламжгүйгээр амьдарч чадах уу?
V363	dm12	Ямар нэгэн тусламж, аппарат хэрэглэдэг эсэх	discrete	numeric	Ямар нэгэн тусламж, аппарат хэрэглэдэг үү?
V364	hi3d	Судалгаа авсан өдөр	contin	numeric	
V365	hi3m	Судалгаа авсан сар	contin	numeric	
V366	hi3y	Судалгаа авсан он	contin	numeric	
V367	hi4	Тоологчийн хувийн дугаар	discrete	numeric	
V368	hi6	Өрхийн байршил	discrete	numeric	
V369	hi7	Нийслэл, аймгийн нэр	discrete	numeric	Нийслэл, аймгийн нэр \ код \?
V370	hi8a	Сууцны төрөл	discrete	numeric	Сууцны төрөл?
V371	hi8b	Өмчийн хэлбэр	discrete	numeric	Өмчийн хэлбэр?
V372	hi8c	Сууцны талбай	contin	numeric	Сууцны талбай?
V373	hi8d	Байшингийн ханын материал	discrete	numeric	Танай байшингийн ханын үндсэн материал юу вэ?
V374	hi8e	Сууцны шалны үндсэн материал	discrete	numeric	Танай сууцны шалны үндсэн материал юу вэ?
V375	hi8f	Өрөөний тоо	contin	numeric	Танай байр хэдэн өрөөтэй вэ?
V376	hi8h	Гэрийн ханын тоо	contin	numeric	Танай гэр хэдэн ханатай вэ?
V377	hi9a	Сууцны халаалтын төрөл	discrete	numeric	Танай сууцны халаалтын төрөл?
V378	hi9b	Түлшний төрөл	discrete	numeric	Танай өрх ямар түлш хэрэглэдэг вэ?
V379	hi9c1	Цахилгаан	discrete	numeric	Танайд дараахи зүйлс /цахилгаан/ бий юу?
V380	hi9c2	Радио	discrete	numeric	Танайд дараахи зүйлс /радио/ бий юу?
V381	hi9c3	Телевизор	discrete	numeric	Танайд дараахи зүйлс /телевизор/ бий юу?
V382	hi9c4	Хөргөгч	discrete	numeric	Танайд дараахи зүйлс /хөргөгч/ бий юу?
V383	hi9d1	Унадаг дугуй	discrete	numeric	Танайд дараахи хөрөнгө /унадаг дугуй/бий юу?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V384	hi9d2	Мотоцикл	discrete	numeric	Танайд дараахи хөрөнгө /Мотоцикл/бий юу?
V385	hi9d3	Суудлын буюу ачааны машин	discrete	numeric	Танайд дараахи хөрөнгө /Суудлын буюу ачааны машин/бий юу?
V386	hi9e	Амины мал	discrete	numeric	Танайх амины малтай юу?
V387	hi9f	Хувийн тариалангийн талбай	discrete	numeric	Хувийн тариалангийн талбайтай юу?
V388	hi9h	Өрхийн нэг хүнд ногдох сарын хэрэглээ/мян.төг/	contin	numeric	Танай өрхийн нэг хүнд ногдох сарын хэрэглээ/мян.төг/хэдэн төгрөг вэ?
V389	hi10	Судалгааны үр дүн	discrete	numeric	
V390	hi11	Судалгаанд хамрагдвал зохих эмэгтэйчүүдийн тоо	contin	numeric	
V391	hi12	Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүд	contin	numeric	
V392	hi13	5 хүртэлх насны хүүхдийн тоо	contin	numeric	
V393	hi14	Судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо	contin	numeric	
V394	hi15	0-18 насны тахир дутуу хүүхдийн тоо	contin	numeric	
V395	hi16	Судалгаанд хамрагдсан тахир дутуу хүүхэд	contin	numeric	
V396	himem	Өрхийн ам бүлийн тоо	contin	numeric	
V397	ws1	Ундны усны эх үүсвэр	discrete	numeric	Танайх ундны усаа хаанаас авдаг вэ?
V398	ws2	Ундны усаа ус түгэх цэгээс авахад зарцуулдаг цаг	contin	numeric	Ундны усаа ус түгэх цэгээс авахад хэдэн цаг зарцуулдаг вэ?
V399	ws3	Ариун цэврийн байгууламжийн төрөл	discrete	numeric	Танайх ямар жорлон хэрэглэдэг вэ?
V400	ws4	Ариун цэврийн байгууламжын байрлал	discrete	numeric	Танай ариун цэврийн байгууламж (жорлон)хаанаа байдаг вэ?
V401	ws5	(0-3 насны) хүүхдийн ялгадас зайлуулалт	discrete	numeric	Хүүхдүүийн (0-3 насны) ялгадасыг хаашаа зайлуулдаг вэ ?
V402	si1	Иоджуулсан давсны хэрэглээ	discrete	numeric	Танай хүнсэндээ хэрэглэж буй давсны иоджуулалтыг шалгаж үзье. Танайх ямар иоджуулсан давсны хэрэглэдэг вэ?
V403	memage	Нас	contin	numeric	
V405	hhmember	Өрхийн гишүүдийн тоо	discrete	numeric	
V406	regcode	Бүсийн нэр	discrete	numeric	Бүсийн нэр
V407	ur	Харъяалал	discrete	numeric	

Women

Агуулга	15-49 настай эмэгтэйчүүдийн түвшинд цуглуулсан мэдээллийн бааз(ОУБТС-2 Эмэгтэйчүүдийн асуулга, Эмэгтэйчүүдийн талаархи мэдээллийн хэсэг, С Хүүхдийн эндэгдэл, Татрангийн эсрэг ТТ вакцинжуулалт, Эх, нярайн эрүүл мэнд, Жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга, хэрэгслийн хэрэглээ, ДОХ өвчний тухай мэдлэг, "Д" витамин дутагдал, Өрхийн мэдээллийн хэсэг ба Ундны болон ариун цэврийн байгууламжийн хангамж)
Тохиолдолууд	8257
Хувьсагч	184
Бүтэц	Төрөл: relational Түлхүүрүүд: wiclno(Түүврийн бүлгийн дугаар), wihhno(Өрхийн дугаар), wilnno(Эмэгтэйн мөрийн дугаар)
Хувилбар	Хувилбар 2.0: Үндэсний тайланд тусгагдсан засварлагдсан мэдээллийн бааз
Гүйцэтгэгч	Үндэсний статистикийн газар, Монгол улс, НҮБ-н Хүүхдийн сан
Missing Data	

Хувьсагчид

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V408	wiclno	Түүврийн бүлгийн дугаар	discrete	numeric	Өрхийн дугаар
V409	wihhno	Өрхийн дугаар	discrete	numeric	
V410	wilnno	Эмэгтэйн мөрийн дугаар	discrete	numeric	
V411	wi1	Эмэгтэйн хувийн дугаар (ХД)	discrete	numeric	Эмэгтэйн хувийн дугаар (ХД)
V412	wi3am	Эмэгтэйн төрсөн сар	contin	numeric	Та хэдэн сард төрсөн бэ?
V413	wi3ay	Эмэгтэйн төрсөн он	contin	numeric	Та хэдэн онд төрсөн бэ?
V414	wi3b	Эмэгтэйн нас	discrete	numeric	Та хэдэн настай вэ ?
V415	cm1	Хүүхэд төрүүлж байсан эсэх	discrete	numeric	Та амьдралынхаа туршид хүүхэд төрүүлж байсан уу?
V416	cm2ad	Анхны хүүхдээ төрүүлсэн өдөр	contin	numeric	Та анхны хүүхдээ хэдний өдөр төрүүлсэн бэ?
V417	cm2am	Анхны хүүхдээ төрүүлсэн сар	contin	numeric	Та анхны хүүхдээ хэдэн сард төрүүлсэн бэ?
V418	cm2ay	Анхны хүүхдээ төрүүлсэн он	contin	numeric	Та анхны хүүхдээ хэдэн онд төрүүлсэн бэ?
V419	cm2b	Анхны төрөлтөөс хойш өнгөрсөн жил	contin	numeric	Хэдэн жилийн өмнө анхны хүүхдээ төрүүлсэн бэ?
V420	cm3	Төрүүлсэн хүүхдүүд одоо хамт амьдардаг эсэх	discrete	numeric	Төрүүлсэн хүүхдүүд тань одоо таньтай хамт амьдардаг уу?
V421	cm4a	Хамт амьдардаг хүүгийн тоо	contin	numeric	Таны төрүүлсэн хэдэн хүү тань одоо Таньтай хамт амьдардаг вэ?
V422	cm4b	Хамт амьдардаг охины тоо	contin	numeric	Таны төрүүлсэн хэдэн охин тань одоо Таньтай хамт амьдардаг вэ?
V423	cm5	Тусдаа амьдардаг хүүхэд	discrete	numeric	Таны төрүүлсэн хүүхдүүдээс тусдаа амьдардаг хүүхэд бий юу?
V424	cm6a	Хамт амьдардаггүй хүүгийн тоо	contin	numeric	Таны төрүүлсэн хүүхдүүдээс хэдэн хүү нь таниас тусдаа амьдардаг вэ?
V425	cm6b	Хамт амьдардаггүй охины тоо	contin	numeric	Таны төрүүлсэн хүүхдүүдээс хэдэн охин нь таниас тусдаа амьдардаг вэ?
V426	cm7	Амьд төрөөд эндсэн хүүхэд	discrete	numeric	Амьд төрөөд эндсэн хүүхэд бий юу?
V427	cm8a	Эндсэн хүү	contin	numeric	Хэдэн хүү нь эндсэн бэ?
V428	cm8b	Эндсэн охин	contin	numeric	Хэдэн охин нь эндсэн бэ?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V429	cm9	Бүгд хэдэн хүүхэдтэй	contin	numeric	Та бүгд хэдэн хүүхэд төрүүлсэн бэ?
V430	cm11d	Хамгийн сүүлчийн төрөлтийн өдөр	contin	numeric	Та, нийт удаа төрснөөс хамгийн сүүлд хэзээ хүүхэд төрүүлсэн (эндсэн хүүхдийг хамааруулна) бэ? Өдөр Хамгийн сүүлчийн төрөлтийн өдөр
V431	cm11m	Хамгийн сүүлчийн төрөлтийн сар	contin	numeric	Та, нийт удаа төрснөөс хамгийн сүүлд хэзээ хүүхэд төрүүлсэн (эндсэн хүүхдийг хамааруулна) бэ? Сар
V432	cm11y	Хамгийн сүүлчийн төрөлтийн он	contin	numeric	Та, нийт удаа төрснөөс хамгийн сүүлд хэзээ хүүхэд төрүүлсэн (эндсэн хүүхдийг хамааруулна) бэ? Он
V433	cm11x	Эцсийн төрөлт сүүлийн жилд хамаарагдаж байгаа эсэх	discrete	character	
V434	tt1	Вакцин хийлгэсэн карт бий эсэх	discrete	numeric	Таньд вакцин хийлгэсэн карт аль эсвэл өөр баримт бичиг бий юу?
V435	tt2	Сүүлчийн хүүхдээ тээж байх үедээ саа, татрангийн эсрэг тарилга хийлгэсэн эсэх	discrete	numeric	Сүүлчийн хүүхдээ тээж байх үедээ саа, татрангийн эсрэг тарилга хийлгэж байсан уу?
V436	tt3	Сүүлчийн жирэмслэлтийн үед хийлгэсэн татрангийн эсрэг вакцины тун	contin	numeric	Сүүлчийн жирэмслэлтийн үед татрангийн эсрэг вакцин хэдэн тунг хийлгэсэн бэ?
V437	tt4	Сүүлчийн хүүхдээ тээх үед, үүнээс өмнөх жирэмслэлтийн үед татрангын эсрэг вакцин хийлгэсэн эсэх	discrete	numeric	Сүүлчийн хүүхдээ тээх үед, үүнээс өмнөх жирэмслэлтийн үед татрангын эсрэг вакцин хийлгэж байсан уу?
V438	tt5	Тариулсан тунгийн хэмжээ	contin	numeric	Хэдэн тунг тариулсан бэ?
V439	tt6am	Сүүлчийн тунг хийлгэсэн сар	discrete	numeric	Сүүлийн тунг хэдэн сард хийлгэсэн бэ?
V440	tt6ay	Сүүлчийн тунг хийлгэсэн он	contin	numeric	Сүүлийн тунг хэдэн онд хийлгэсэн бэ?
V441	tt6b	Жилийн өмнө сүүлийн тунг хийлгэсэн эсэх	contin	numeric	Жилийн өмнө сүүлийн тунг хийлгэсэн үү?
V442	tt7	Бүгд хийлгэсэн тун	contin	numeric	Бүгд хэдэн тунг хийлгэсэн бэ?
V443	mn1	Төрсний дараа "А" амин дэмийг уусан эсэх	discrete	numeric	Төрсний дараахи эхний хоёр сард Та "А" амин дэмийг ийм тунгаар уусан уу?
V444	mn2a	Төрөхийн өмнөх үзлэг: Эмч	discrete	numeric	Төрөхөөсөө өмнө Та эмчид үзүүлж байсан уу?
V445	mn2b	Төрөхийн өмнөх үзлэг: Сувилагч/эх баригч	discrete	numeric	Төрөхөөсөө өмнө Та Сувилагч/эх баригчид үзүүлж байсан уу?
V446	mn2c	Төрөхийн өмнөх үзлэг: Туслах эх баригч	discrete	numeric	Төрөхөөсөө өмнө Та Туслах эх баригчид үзүүлж байсан уу?
V447	mn2d	Төрөхийн өмнөх үзлэг: Бариач	discrete	numeric	Төрөхөөсөө өмнө Та Бариачид үзүүлж байсан уу?
V448	mn2f	Төрөхийн өмнөх үзлэг: Бусад	discrete	numeric	Төрөхөөсөө өмнө Та Бусад (тодруулж бич)-д үзүүлж байсан уу?
V449	mn2z	Төрөхийн өмнөх үзлэг: Үзүүлж байгаагүй	discrete	numeric	Төрөхөөсөө өмнө Та хэн нэгэнд үзүүлж байсан уу?
V450	mn3a	Сүүлийн төрөлтийг эх барьж авсан:Эмч	discrete	numeric	Сүүлийн төрөлтийг хэн эх барьж авсан бэ?Эмч
V451	mn3b	Сүүлийн төрөлтийг эх барьж авсан:Сувилагч/эх баригч	discrete	numeric	Сүүлийн төрөлтийг хэн эх барьж авсан бэ?Сувилагч/эх баригч
V452	mn3c	Сүүлийн төрөлтийг эх барьж авсан:Туслах эх баригч	discrete	numeric	Сүүлийн төрөлтийг хэн эх барьж авсан бэ?Туслах эх баригч

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V453	mn3d	Сүүлийн төрөлтийг эх барьж авсан:Бариа	discrete	numeric	Сүүлийн төрөлтийг хэн эх барьж авсан бэ?Бариа
V454	mn3e	Сүүлийн төрөлтийг эх барьж авсан:Хамаатан, ойр дотны хүн	discrete	numeric	Сүүлийн төрөлтийг хэн эх барьж авсан бэ?Хамаатан, ойр дотны хүн
V455	mn3f	Сүүлийн төрөлтийг эх барьж авсан:Бусад	discrete	numeric	Сүүлийн төрөлтийг хэн эх барьж авсан бэ?Бусад
V456	mn3z	Сүүлийн төрөлтийг эх барьж авсан: Хэн ч байгаагүй (өөрөө)	discrete	numeric	Сүүлийн төрөлтийг хэн эх барьж авсан бэ?Хэн ч байгаагүй (өөрөө)
V457	mn4	Төрүүлсэн хүүхдийн хэмжээ	discrete	numeric	Таны сүүлийн төрүүлсэн хүүхэд ямар хэмжээний жинтэй төрсөн бэ?
V458	mn5	Төрүүлсэн хүүхдийн жин хэмжсэн эсэх	discrete	numeric	Танай хүүхдийг төрөх үед биеийн жинг нь хэмжсэн үү?
V459	mn6a	Төрүүлсэн хүүхдийн жин байгаа эсэх	discrete	numeric	Хүүхэд ямар жинтэй төрсөнийг мэдэх үү?
V460	mn6	Төрүүлсэн хүүхдийн жин (граммаар)	contin	numeric	Хүүхэд ямар жинтэй төрсөн бэ?
V461	mn7	Сүүлчийн жирэмслэлтийн үед нүдний хараа өдрийн цагаар муудаж байсан эсэх	discrete	numeric	Сүүлчийн жирэмслэлтийн үед өдрийн цагаар таны нүдний хараа муудаж байсан уу?
V462	mn8	Сүүлчийн жирэмслэлтийн үед нүдний хараа шөнийн цагаар муудаж байсан эсэх	discrete	numeric	Сүүлчийн жирэмслэлтийн үед шөнийн цагаар таны нүдний хараа муудаж байсан уу?
V463	cu1	Гэрлэсэн эсвэл хамтран амьдардаг	discrete	numeric	Та гэрлэсэн үү эсвэл хамт амьдардаг уу?
V464	cu2	Одоо жирэмсэн эсэх	discrete	numeric	Та одоо жирэмсэн үү?Одоо жирэмсэн эсэх
V465	cu3	Жирэмслэлтээс сэргийлж ямар нэг арга хэрэглэдэг эсэх	discrete	numeric	Та жирэмслэлтээс сэргийлж ямар нэг арга хэрэглэдэг үү?
V466	cu4a	Жирэмслэлтээс хамгаалах арга: Эмэгтэйн үрийн хоолойг боох	discrete	numeric	Та Эмэгтэйн үрийн хоолойг боох аргыг хэрэглэдэг үү?
V467	cu4b	Жирэмслэлтээс хамгаалах арга: Эрэгтэйн үрийн сувгийг боох	discrete	numeric	Та Эмэгтэйн үрийн хоолойг боох аргыг хэрэглэдэг үү?
